МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

# ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023
# СУУРЬ БОЛОВСРОЛ

8 АНГИ

# ТҮҮХ

*ХУВИЛБАР* ***А***

Аймаг / дүүрэг: ..........................................................................

Сум / сургууль: ..........................................................................

Анги / бүлэг: ..........................................................................

Сурагчийн овог: ..........................................................................

Сурагчийн нэр: ..........................................................................

Сурагчийн код: ..........................................................................

**САНАМЖ**

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

**1.** 1585 онд Хархорум хотын суурин дээр баригдаж, ЮНЕСКО-гийн дэлхийн соёлын өвд орсон хийд аль вэ?

A. Амарбаясгалант хийд  B. Эрдэнэ зуу хийд
C. Манзушир хийд  D. Төвхөн хийд

**2.** Цэгийн оронд тохирох утгыг нөхнө үү.
1587 онд Аюуш гүүш Энэтхэг, Төвөд үгийг монгол бичгээр галиглах ................ үсгийг зохиожээ.

A. Тод үсэг  B. Соёмбо үсэг  C. Али гали  D. Ганжуур

**3.** Бурхны шашин дэлгэрсэнтэй холбоотойгоор монголчуудын амьдралд ямар өөрчлөлт гарсан бэ?

A. Эрэгтэй эмэгтэй хөгшин залуугүй заримдаа гараасаа эрих салгахгүй явах болсон
B. Эсгий ширж хээ угалзаар чимэглэх болсон
C. Гэрийн тооно авсаархан болж, нүүх, тээвэрлэхэд улам тохиромжтой болсон
D. Жилийн дөрвөн улирал, аж байдалдаа зохицсон нүүдлийн мал аж ахуй эрхлэх болсон

**4.** Их Юань улсын ноёрхол эцэс болсны дараа Хятадад ямар улс байгуулагдсан бэ?

A. Сүн улс  B. Мин улс  C. Гуулин улс  D. Хань улс

**5.** Хятадууд Манжийн захиргаанд үг дуугүй захирагдахын бэлгэдэл нь юу байсан бэ?

A. Тав гэзэг тавих  B. Дээл өмсөх
C. Газар тариалан эрхлэх  D. Өдөр болгон залбирах

**6.** Их Могол улсын Шах Жаханы зарлигаар 1630-1653 онд Умард Энэтхэгт бүтээн байгуулсан дэлхийн долоон гайхамшгийн тоонд ордог байгууламж аль вэ?

A. Цагаан хэрэм  B. Чичен Итза  C. Колизей  D. Таж Махал

**7.** Газарзүйн зурагт “2”-ын тоогоор ямар нутаг дэвсгэрийг харуулсан байна вэ?




A. Халх  B. Өвөр Монгол
C. Шинжаан  D. Төвөд

**8.** Манж нар 1637 онд Чусоныг эзлэн, түшмэг улсаа болгож, Хятадтай хийх байлдаанд хөлөг онгоц, зэвсэг хэрэглэл, хүн хүчний туслалцаа үзүүлэх үүргийг хүлээлгэжээ. Уг үйл явдал хэддүгээр зуунд, буюу одоогоос хэдэн жилийн өмнө болсон бэ?

A. XVI зуунд, 3660 жилийн өмнө
B. XVII зуунд, 368 жилийн өмнө
C. XVII зуунд, 3660 жилийн өмнө
D. XVI зуунд, 368 жилийн өмнө

**9.** 1492 оны 10-р сарын 12 нд Төв Америкийн арлуудад хүрч, Америк тивийг нээсэн хүн хэн бэ?

A. Фернан Магеллан    B. Васко да Гама
C. Христофер Колумб    D. Тосканелл

**10.** Италийн физикч, одон орон судлаач Галилео Галилейн зохион бүтээсэн бүтээл аль вэ?

A. Хэвлэлийн машин    B. Дэлхийн хөдөлгөөний хууль
C. Одон орны дуран    D. Нисдэг машин

**11.** XIII зууны II хагасаас XIV зууны үед дундад зуунд утга зохиолын үндсэн хэл байсан Латин хэлийг аажмаар тухайн ард түмний хэлээр сольж байв. Уг үе нь Сэргэн мандалтын аль үед хамаарах вэ?

A. Сэргэн мандалтын эхэн үе    B. Түрүү Сэргэн мандалтын үе
C. Сэргэн мандалтын оргил үе    D. Сэргэн мандалтын бууралтын үе

**12.** Аялагчдын нээсэн газруудыг зөв холбосныг сонгоорой.

1. Х.Колумб    a. Номхон далай
2. Ф.Магеллан    b. Америк тив
3. Васко да Гама    c. Сайн итгэлтийн хошуу

A. 1a, 2b, 3c    B. 1b, 2c, 3a    C. 1b, 2a, 3c    D. 1a, 2c, 3b

**13.** Газрын зурагт “1” дугаараар аль улсын колонийг тэмдэглэсэн байна вэ?

A. Испани    B. Португали
C. Их Британи    D. Франц



**14.** Зуун жилийн дайн аль улсын ялалтаар дууссан бэ?

A. Англи B. Франц C. Испани D. Турк

**15.** Испаничууд 1588 онд Английн эсрэг 130 орчим онгоц бүхий усан флотоо илгээжээ. Уг усан флотыг юу гэж нэрэлдэг байсан бэ?

A. Хашаалалт B. Ялагдашгүй Армада C. Реформац D. Гуманист

**16.** Цэгийн оронд тохирох нэрийг нөхнө үү.
1682 онд .............. Оросын хаан ширээнд суусан ба тэрээр баруун Европын үлгэр жишээгээр улс орноо хөгжүүлэх бодлого баримталж байв.

A. Алексей I Михайлович B. I Петр Алексеевич
C. Владимир Ильич Ленин D. Иосиф Сталин

**17.** Зуун жилийн дайн 1337 оноос эхлэв. Тэгвэл уг үйл явдал хэддүгээр жаранд болсныг тооцоолоорой.

A. 1 дүгээр B. 3 дугаар C. 5 дугаар D. 6 дугаар

**18.** 1640 онд Англид хөрөнгөтний хувьсгал дэгдэв. Уг үйл явдал хэддүгээр зуунд хамаарах ба одоогоос хэдэн жилийн өмнө болсон бэ?

A. XVII зуун, 383 жилийн өмнө B. XVI зуун, 3663 жилийн өмнө
C. XVII зуун, 3663 жилийн өмнө D. XVI зуун, 383 жилийн өмнө

**19.** Манжийн төр Монголын бүх хошууг дотоод, гадаад засаг хошуу гэж хувааж байлаа. Дотоод Монголын хошууд гэж алийг хэлдэг байсан бэ?

A. Өвөр Монголыг B. Халхыг C. Хөх нуурыг D. Эзнээ Алшааг

**20.** Зурагт Монголын түүхэн зүтгэлтэн хэн байна вэ?



A. Амарсанаа B. Тогтохтөр
C. Чингүнжав D. Жавзандамба

**21.** Манжийн эрх баригчид шашныг бүх талаар дэмжин дэлгэрүүлж, шашны үзэл номлолыг ашиглаж байсан нь ард олныг ямар зан авиртай болгох бодлого вэ?

A. Зоригтой, тууштай
B. Хөдөлмөрч, ууртай
C. Зөрүүд, гөжүүд
D. Номхон, хүлцэнгүй

**22.** 1755 – 1758 оны үед Манжийн эрхшээлийн эсрэг Ойрад Монголчуудыг удирдаж тусгаар тогтнолын төлөө тэмцсэн хүн хэн бэ?

A. Чингүнжав
B. Амарсанаа
C. Жавзандамба
D. Тогтохтөр

**23.** Түмэн засагт хаан улс орноо ямар арга замаар нэгтгэх бодлого хэрэгжүүлсэн бэ?

A. Зүүн, баруун түмнийг эвлэрүүлэх
B. Баруун, зүүн түмнийг хагаралдуулах
C. Мин улстай нэгдэж Зүүн, баруун түмнийг нэгтгэх
D. Бүх Монголыг цэргийн хүчээр дарж нэгтгэх

**24.** Түүхэн сурвалж бичгүүдэд “Гар газар, хөл хөсөр” хэмээн ямар хааны үеийг тэмдэглэн бичсэн байдаг вэ?

A. Түмэн засагт хаан
B. Батмөнх даян хаан
C. Тогоонтөмөр хаан
D. Галдан бошгот хаан

**25**. Монголчуудын Манжийн эрхшээлд орсон он цагийг зөв харгалзуулаарай.

1. Өвөр Монгол — A.1755 он
2. Халх Монгол — B.1691 он
3. Ойрад Монгол — C.1636 он

A. 1a,2b,3a
B. 1b,2a,3c
C. 1c,2b,3a
D. 1a,2c,3b